

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХАМГААЛАЛТ, ОРЛОГО, АШИГ, ТАТВАР, ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН АСУУДЛУУД

Ц.Зоригтбат

Санхүүгийн бодлогын газрын дарга




САНГИЙН ЯАМ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭ



МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГО



ТӨСВИЙН БОДЛОГО




ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ



**УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙГ САЙЖРУУЛАХ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ИТГЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ**

МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГО



Эх сурвалж: ОУВС

Макро зохистой бодлогын хүрээнд төсөв-мөнгөний бодлого, санхүүгийн тогтвортой байдал уялдах ёстой байдаг.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



САНГИЙН ЯАМ



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



ХАДГАЛАМЖИЙН
ДААТГАЛЫН
КОРПОРАЦИ
DEPOSIT INSURANCE CORPORATION OF MONGOLIA

Энэ уялдааг санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр дамжуулан шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна.

2018 ОНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСВИЙН БОДЛОГО



ДУНД ХУГАЦААНД БАРИМТЛАХ БОДЛОГЫН СТРАТЕГИ



Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн “Цахим, ил тод, үр ашигтай” төсвийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ;



Засгийн газрын 2012-2016 онд гаргасан бондуудыг 2021-2023 онуудад эргэн төлөхтэй холбогдуулан төсвийн алдагдлыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хэмжээнээс сайжруулан 2021 онд ДНБ-ий -2.8 хувь, 2022 онд ДНБ-ий -1.4 хувь, цаашид 2023 оноос ашигтай гаргах бодлого баримтална;



Засгийн газрын зүгээс 2021-2024 онуудад төлөгдөх нийт 2.9 тэрбум ам.долларын өндөр хүүтэй гадаад үнэт цаасны төлбөрийг төсөв болон эдийн засагт дарамт үүсгэхгүй байх өрийн менежментийг хэрэгжүүлнэ;



Татвар, гаалийн шинэчлэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж бизнесийн орчныг сайжруулна;



Тэтгэвэр, тэтгэмж болон төрийн албан хаагчдын цалин хөлсийг зөвхөн инфляцтай уялдуулан нэмэгдүүлнэ;



Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар батлагдсан 2020 онд шилжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг бүрэн санхүүжүүлнэ. Байгалийн түүхийн музей, Үндэсний урлагийн их театр барих ажлыг эхлүүлж, Үндэсний номын сангийн тоног төхөөрөмжийг шинэчилнэ;




Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор Төрийн санд байршуулна;




Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтыг цахимжуулах замаар иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэн үр ашгийг сайжруулна.


ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ




Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс бусад этгээдийн барилга байгууламжийн элэгдэл байгуулах хугацааг 40-өөс 25 жил болгон бууруулах,




Татварын зорилгоор орлого, зарлага хүлээн зөвшөөрөх зарчмыг тодорхой болгох,




Хөрөнгийн зах зээлийг дэмжих татварын бодлогыг хэрэгжүүлж, нээлттэй арилжаалах хувьцаа, хувь оролцооны ногдол ашиг, өрийн хэрэгслийн хүүгийн орлогод ногдох суутган татварын хувь хэмжээг бууруулна.



Зээлийн хүүг бууруулах зорилтын хүрээнд арилжааны банкны татан төвлөрүүлсэн зээлийн хүүгийн болон хувьцааны ногдол ашгийн орлогод ногдох суутган татварыг бууруулна.



Монгол Улсад бүртгэлтэй татвар төлөгчийн гадаад улсад төлсөн татварыг давхардуулан ногдуулахгүй байх зэрэг бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж хөрөнгө оруулалтыг дэмжинэ.



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИДЭВХЖИЛ

Үнэт цаасны зах зээл



Эх сурвалж: СЗХ

Олон улсын зах зээлээс татсан хөрөнгө оруулалт



МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК

500 сая ам.доллар



300 сая ам.доллар

- Хөрөнгө оруулагч, даатгуулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах
- Ил тод, өрсөлдөөн бүхий, үр ашигтай зах зээлийн тогтолцоог бүрдүүлэх
- Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн шинэчлэл
- Хууль, эрх зүйн зохицуулалт, хяналтын орчны шинэчлэл
- Салбарын оролцогчдын чадавхжуулалт, идэвхжүүлэлт
- Санхүүгийн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН 2019-2022 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧИГ

1

Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас, зээлийн төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна.

2

Гадаад зээллэгээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдэд зардал, үр өгөөжийн тооцооллыг хийж, зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэх зарчмыг баримталж, тэдгээрийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулна.

3

Орчин үеийн технологийн дэвшлийг ашигласан Засгийн газрын үнэт цаасны арилжааны дэд бүтцийг бүрдүүлнэ. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох боломжийг нэмэгдүүлж, зах зээлийн нээлттэй, өрсөлдөөнт, хүртээмжтэй байдлыг хангаж, Засгийн газрын үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулна.

4

Болзошгүй өр төлбөрийн төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлэх, болзошгүй эрсдэлээс сэргийлэх тогтолцоог хөгжүүлнэ.

5

Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх.

Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж, Засгийн газрын санхүүгийн хэрэгцээг боломжит эрсдэлийн түвшинд хамгийн бага зардлаар санхүүжүүлэхэд чиглэнэ.



САНГИЙН ЯАМ

**АНХААРАЛ ХАНДУУЛСАН
ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА**